



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/109

Чойр

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 48.2.3, 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, Байгаль орчин, Аялал жуулчлалын сайдын 2024 оны А/53 дугаартай тушаалыг тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх “Говьсүмбэр аймагт 10га талбайд байгалийн ургамал тарьж элсний ургамлан бүрхэвчийн талбайг нэмэгдүүлэх ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Б.Болд-Эрдэнэ

(Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга)

Гишүүд:

Т.Дашцэдэн

(Сум дундын ойн ангийн дарга)

М.Номинзул

(Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)

Хөндлөнгийн төлөөлөл:

Л.Буяндэлгэр

(Сүмбэр сумын 2 дугаар багийн иргэн)

Нарийн бичгийн дарга:


Г.Номин-Эрдэнэ

(Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллахыг үнэлгээний хорооны дарга (Б.Болд-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3.Үнэлгээний хорооны зөвлөмжид үндэслэн шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтаар бий болсон өмч хөрөнгийг бүртгэл, тайланд тусгаж, эзэмшил ашиглалтад хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ

4212400254